

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/92/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 114

танай _____ -ны № _____ -т

ДАРХАН УУЛ АЙМГИЙН 1 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Т.МЭДЭГСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 56,840.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Орон нугийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 118,983.5 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, Хүүхэд хөгжлийн танхим байгуулахад 12,500.0 мянган төгрөгийн бараа материал, компьютер, тавилгыг холбогдох дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4520050113

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 2,518,066.0 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 27.1 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Дархан Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр сургуулийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 79 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 95.0 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр БГ-т ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	290.788.852.48	149.769.737.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	200,612,645.03	17,440,293.01
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	200,612,645.03	17,440,293.01
3121	Төгрөг	200,612,645.03	17,440,293.01
31211	Төрийн сангийн харилцах	200,612,645.03	17,440,293.01
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		5,629,973.88
335	Бусад авлага		5,629,973.88
3351	Байгууллагаас авах авлага		5,629,973.88
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	90,176,207.45	126,699,470.32
351	Түүхий эд материал	889,190.00	224,650.00
	Эм боох материал	889,190.00	224,650.00
354	Хангамжийн материал	89,287,017.45	126,474,820.32
3541	Бичиг хэргийн материал	172,000.00	-
3542	Аж ахуйн материал	33,306,321.25	52,218,021.25
3547	Бусад хангамжийн материал	55,808,696.20	74,256,799.07
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,712,172,433.87	3,689,938,070.66
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,712,172,433.87	3,689,938,070.66
392	Биет хөрөнгө	3,178,030,837.42	3,151,046,474.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,836,970,320.00	2,836,970,320.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(532,746,214.02)	(614,959,225.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	681,642,421.74	737,504,247.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	(299,182,065.77)	(260,209,972.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	301,564,888.71	295,096,335.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	(132,214,243.86)	(133,662,118.54)
39214	Бусад үндсэн хөрөнгө	358,734,373.00	375,604,265.84
39215	Хуримтлагдсан элэгдэл	(88,958,133.08)	(128,505,739.66)
39217	Ном	52,219,490.70	43,208,360.50
393	Биет бус хөрөнгө	534,141,596.45	538,891,596.41
39301	Програм хангамж	2,324,300.00	8,324,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,211,870.02)	(3,111,870.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	540,696,000.00	540,696,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(6,666,833.53)	(7,016,833.57)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,002,961,286.35	3,839,707,807.87
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,054,700.00

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		9,054,700.00
413	Өглөг		9,054,700.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		9,054,700.00
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,002,961,286.35	3,830,653,107.87
51	Засгийн газрын хувь оролцоо	4,002,961,286.35	3,830,653,107.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,565,471,243.90	1,565,471,243.90
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,565,471,243.90	1,565,471,243.90
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	(662,145,616.88)	(834,453,795.36)
5121	Өмнөх үеийн үр дүн	(662,145,616.88)	(662,145,616.88)
5122	Тайлант үеийн үр дүн		(172,308,178.48)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,099,635,659.33	3,099,635,659.33
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,002,961,286.35	3,839,707,807.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,010,663,921.80	3,464,113,224.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	338,195,821.80	274,195,824.68
120	Нийтлэг татварын бус орлого	338,195,821.80	274,195,824.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,126,844.00	14,155,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,721,100.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,405,744.00	14,155,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	146,888,819.20	199,557,535.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	174,180,158.60	60,483,288.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,672,468,100.00	3,189,917,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,589,537,300.00	3,106,161,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,589,537,300.00	3,106,161,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,930,800.00	83,755,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,930,800.00	83,755,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,063,159,972.93	3,626,455,137.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,063,159,972.93	3,626,455,137.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,885,028,649.76	3,369,961,299.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,980,366,158.60	2,518,066,005.12
210101	Үндсэн цалин	1,250,367,914.60	1,434,302,188.80
210102	Нэмэгдэл	634,237,229.00	789,631,524.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		78,465,793.00
210104	Урамшуулал	95,761,015.00	215,666,499.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	245,812,200.00	313,152,566.79
210201	Тэтгэврийн даатгал	167,892,300.00	212,316,666.79
210202	Тэтгэмжийн даатгал	19,205,000.00	25,209,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,752,500.00	12,604,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,752,500.00	12,604,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,209,900.00	50,417,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,997,407.83	63,545,592.21
210301	Гэрэл, цахилгаан	13,832,141.31	20,632,461.29
210302	Түлш, халаалт	32,981,318.04	26,942,393.72
210303	Цэвэр, бохир ус	15,183,948.48	15,970,737.20
2104	Хангамж, бараа материалын зардал	3,885,457.40	14,230,710.00
210401	Бичиг хэрэг	150,000.00	4,885,250.00
210404	Ном хэвлэл		330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,735,457.40	8,564,600.00
210408	Бараа материал акталсны зардал	-	0.00

2105	Нормативт зардал	0.00	450,860.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	450,860.00
210502	Хоол, хүнс		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	186,999,380.00	55,067,903.52
210604	Урсгал засвар	186,999,380.00	55,067,903.52
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,441,746.40	43,325,312.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,686,100.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,755,646.40	43,325,312.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	370,526,299.53	362,573,209.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,601,129.99	67,848,120.47
210902	Хичээл үйлдэрлэлийн дадлага хийх	19,451,280.00	27,106,955.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	258,473,889.54	267,618,133.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	178,131,323.17	256,493,837.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	178,131,323.17	256,493,837.79
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	133,338,700.00	204,086,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,715,000.00	47,322,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,077,623.17	5,084,937.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,077,623.17	5,084,937.79
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(52,496,051.13)	(162,341,912.38)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,029,215.70	9,966,266.10
225001	Үндсэн хөрөнгө худалдсны гарз	9,759,253.00	9,966,266.10
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	1,269,962.70	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,029,215.70)	(9,966,266.10)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(63,525,266.83)	(172,308,178.48)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,689,594,944.00	3,204,072,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,126,844.00	14,155,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,126,844.00	14,155,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,126,844.00	14,155,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,721,100.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,405,744.00	14,155,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,672,468,100.00	3,189,917,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,589,537,300.00	3,106,161,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,589,537,300.00	3,106,161,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,930,800.00	83,755,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,930,800.00	83,755,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,620,615,602.77	3,331,452,252.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,620,615,602.77	3,331,452,252.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,442,484,279.60	3,074,958,414.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,980,366,158.60	2,512,681,845.79
210101	Үндсэн цалин	1,250,367,914.60	1,437,244,188.80
210102	Нэмэгдэл	634,237,229.00	789,631,524.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		78,465,793.00
210104	Урамшуулал	95,761,015.00	207,340,339.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	245,812,200.00	315,112,000.00
210201	Тэтгэврийн даатгал	167,892,300.00	214,276,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,205,000.00	25,209,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,752,500.00	12,604,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,752,500.00	12,604,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,209,900.00	50,417,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,997,407.83	63,545,592.21
210301	Гэрэл, цахилгаан	13,832,141.31	20,632,461.29
210302	Түлш, халаалт	32,981,318.04	26,942,393.72
210303	Цэвэр, бохир ус	15,183,948.48	15,970,737.20
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	0.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	
210502	Хоол, хүнс		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,261,513.00	21,979,970.00
210604	Урсгал засвар	16,261,513.00	21,979,970.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,125,470.17	52,272,276.23

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,686,100.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,439,370.17	52,272,276.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,921,530.00	109,366,730.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,631,300.00	92,812,730.00
210902	Хичээл үйлдэрлэлийн дадлага хийх	22,290,230.00	16,554,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	178,131,323.17	256,493,837.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	178,131,323.17	256,493,837.79
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	133,338,700.00	204,086,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,715,000.00	47,322,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,077,623.17	5,084,937.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,077,623.17	5,084,937.79
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	68,979,341.23	(127,379,852.02)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ҮН ДҮН (5)	57,382,000.00	55,792,500.00
	Дотоод эх үүсвэрээр	57,382,000.00	55,792,500.00
223001	Бусад хөрөнгө	57,382,000.00	55,792,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(57,382,000.00)	(55,792,500.00)
145	Бусад эх үүсвэр	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11,597,341.23	(183,172,352.02)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	189,015,303.80	200,612,645.03
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	200,612,645.03	17,440,293.01

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,565,471,243.90	3,099,635,659.33	(598,620,350.05)	4,066,486,553.18
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			(63,525,266.83)	(63,525,266.83)
8				
9				
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,565,471,243.90	3,099,635,659.33	(662,145,616.88)	4,002,961,286.35
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			(172,308,178.48)	(172,308,178.48)
18				
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,565,471,243.90	3,099,635,659.33	(834,453,795.36)	3,830,653,107.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,439,343,400.00	3,382,159,814.23	(57,183,585.77)	98.3%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,439,343,400.00	3,382,159,814.23	(57,183,585.77)	98.3%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,165,113,200.00	3,074,958,414.23	(90,154,785.77)	97.2%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,512,802,700.00	2,512,681,845.79	(120,854.21)	99.99%
210101	Үндсэн цалин	1,569,619,000.00	1,437,244,188.80	(132,374,811.20)	91.6%
210102	Нэмэгдэл	810,502,000.00	789,631,524.00	(20,870,476.00)	97.4%
210103	Унаа хоолны хөнгөлөлт		78,465,793.00	78,465,793.00	
210104	Урамшуулал	132,681,700.00	207,340,339.99	74,658,639.99	156.3%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	315,112,000.00	315,112,000.00	-	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	214,276,100.00	214,276,100.00	-	100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	25,209,000.00	25,209,000.00	-	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,604,500.00	12,604,500.00	-	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	12,604,500.00	12,604,500.00	-	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	50,417,900.00	50,417,900.00	-	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,706,600.00	63,545,592.21	(29,161,007.79)	68.5%
210301	Гэрэл, цахилгаан	20,309,200.00	20,632,461.29	323,261.29	101.6%
210302	Түлш, халаалт	54,609,700.00	26,942,393.72	(27,667,306.28)	49.3%
210303	Цэвэр, бохир ус	17,787,700.00	15,970,737.20	(1,816,962.80)	89.8%
2104	Хангамж, бараа материалын зардал			-	0.0%
2105	Нормативт зардал	-	-	-	0.0%
210502	Хоол, хүнс	-	-	-	0.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,980,000.00	21,979,970.00	(30.00)	100.0%
210604	Урсгал засвар	21,980,000.00	21,979,970.00	(30.00)	100.0%
2107	Томилолт, зочны зардал	-	-	-	0.0%
210702	Дотоод албан томилолт		-	-	0.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,028,600.00	52,272,276.23	(6,756,323.77)	88.6%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	59,028,600.00	52,272,276.23	(6,756,323.77)	88.6%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	163,483,300.00	109,366,730.00	(54,116,570.00)	66.9%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	146,929,300.00	92,812,730.00	(54,116,570.00)	63.2%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,554,000.00	16,554,000.00	-	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	274,230,200.00	251,408,900.00	32,971,200.00	91.7%
2132	Бусад урсгал шилжүүлэг	274,230,200.00	251,408,900.00	(22,821,300.00)	91.7%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж олгох урамшуулал	226,908,100.00	204,086,800.00		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	47,322,100.00	47,322,100.00	-	100.0%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох		-	-	0.0%
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	0.0%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		55,792,500.00	55,792,500.00	0.0%
	Дотоод эх үүсвэрээр		55,792,500.00	55,792,500.00	0.0%
223001	Бусад хөрөнгө		55,792,500.00	55,792,500.00	0.0%
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,439,343,400.00	3,198,987,462.21	(240,355,937.79)	93.0%

131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,120,240,100.00	3,106,161,900.00	(14,078,200.00)	99.5%
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,120,240,100.00	3,106,161,900.00	(14,078,200.00)	99.5%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			-	0.0%
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	109,486,600.00	78,670,562.21	(30,816,037.79)	71.9%
132001	Орон нутгийн төсвөөс	109,486,600.00	78,670,562.21	(30,816,037.79)	71.9%
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС			-	0.0%
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			-	0.0%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	209,616,700.00	14,155,000.00	(195,461,700.00)	6.8%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,000,000.00	14,155,000.00	3,155,000.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	198,616,700.00	-	(198,616,700.00)	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			-	0.0%
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		200,612,645.03	-	0.0%
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	17,440,293.01	-	0.0%
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	0.0%
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0%
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	89.00	88.00	(1.00)	98.9%
6	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
7	Гүйцэтгэх ажилтан	89.00	88.00	(1.00)	98.9%
8	Үйлчлэх ажилтан	101.00	101.00	-	100.0%
9	Гэрээт ажилтан			-	0.0%
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,180.00	1,311.00	131.00	111.1%
14	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА				0.0%
15	Төрийн өмчит СӨБ байгууллага				0.0%
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)				

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 137,206.5 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав.

- Тус сургуулийн хөрөнгөнд тооллого хийхэд БГ-ын хөрөнгө оруулалтаар Чиглэл ХХК-наас 2025.06.17 болон 2025.06.20-ны өдөр нийлүүлсэн 91 нэр төрлийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, багаж хэрэгсэлийг эрх бүхий байгууллагаас шийдвэр ирээгүй нь улмаас хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулан тусгагдаагүй хөрөнгийг бүртгэх

Аудитаар нийт 18,659.8 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул төсвийг хохиролгүй болгох 1,075.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,619.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 14,965.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Тайлант онд тус сургуулийн захирал Т.Мэдэгсүрэнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүйгээс нийт 475.2 мянган төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх “Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно”, 56.2 дах “Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно” заасантай тус тус нийцэхгүй байна.

5.1.2 Илрүүлэлт: Тайлант онд тус сургуулийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан захирал Т.Мэдэгсүрэнгийн сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 7-д “Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих зардал (Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх) буюу Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

Тайлант онд тус сургуулийн захирал Т.Мэдэгсүрэн нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

2,619.2 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В дэх хэсэгт “Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Авлага, өр төлбөрийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Тус байгууллагын авлагын дансанд 5,630.0 мянган төгрөгийн авлага байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Тус байгууллагын өр төлбөрийн дансанд 9,054.7 мянган төгрөгийн өр төлбөр байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасныг баримтлан, авлагыг барагдуулах арга хэмжээ авч, барагдахгүй авлагыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх ажлын зохион байгуулаж ажиллах

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасныг хэрэгжүүлэн, өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах

2. Цалингийн данстай холбоотой асуудал

1.2 Илрүүлэлт

Тайлант оны эхний хагас жилийн байдлаар нярав Л.Хөхөө нь ХАБЭА ажилтан, манаач Д.Ариунболд нь цахилгаанчинг хавсран гүйцэтгэсэн цалинг тооцохдоо 2023 оны Монгол улсын Засгийн газрын "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" тогтоолыг үндэслэн албан тушаалын зэрэглэлийг тооцоогүй улмаас хавсран гүйцэтгэсэн цалинг 280.8 мянган төгрөгөөр дутуу тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах

Тайлангийн 5.1, 5.2, 5.3 дах хэсэгт дурдсан акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Тус сургуулийн хөрөнгөнд тооллого хийхэд БГ-ын хөрөнгө оруулалтаар Чиглэл ХХК-наас 2025.06.17 болон 2025.06.20-ны өдөр нийлүүлсэн 91 нэр төрлийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, багаж хэрэгсэлийг эрх бүхий байгууллагаас шийдвэр ирээгүй нь улмаас хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулан тусгагдаагүй хөрөнгийг бүртгэх	1	137,206.5	1	137,206.5	-	-	1	137,206.5	-	-	-	-
Дүн	1	137,206.5	1	137,206.5	-	-	1	137,206.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд тус сургуулийн захирал Т.Мэдэгсүрэнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүйгээс нийт 475.2 мянган төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна..	1	475.2	1	475.2								
Тайлант онд тус сургуулийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад	1	600.0	1	600.0								

хамрагдсан захирал Т.Мэдэгсүрэнгийн сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.												
Тайлант онд тус сургуулийн захирал Т.Мэдэгсүрэн нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,619.2 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	2,619.2			1	2,619.2						
Тус сургуулийн удирдлага нь тайлант онд байгууллагаас авах авлага, ажилчидтай холбоотой 14,684.6 мянгаан төгрөгийн өглөгтэй тайлагнасан	1	14,684.6					1	14,684.6				
Эхний хагас жилийн байдлаар нярав Л.Хөхөө нь ХАБЭА ажилтан, манаач Д.Ариунболд нь цахилгаанчинг хавсран гүйцэтгэсэн цалинг тооцохдоо 2023 оны Монгол улсын Засгийн газрын "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл,албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" тогтоолыг үндэслэн албан тушаалын зэрэглэлийг тооцоогүй улмаас хавсран гүйцэтгэсэн цалинг 280.8 мянган төгрөгөөр дутуу тооцож олгосон байна.	1	280.8					1	280.8				
Дүн	5	18,659.8	2	1,075.2	1	2,619.2	2	14,965.4	-	-	-	-